

**ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООДЫН 2015 ОНЫ ХОЁРДУГААР УЛИРЛЫН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2015.08.18

Улаанбаатар хот

НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Тайлант улиралд Хорооны хуралдаанаар 86 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, 3 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, 10 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, түдгэлзүүлсэн 1 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээх зэрэг 100 танилцуулга, шийдвэрийн төслийг хэлэлцүүлж зохицуулалтын арга хэмжээ авсан бөгөөд 2015 оны эхний хагас жилийн байдлаар нийт 242 хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/ Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.


Хадгаламж, зээлийн хоршоодыг үйл ажиллагааны төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

№	Үйл ажиллагааны нэр төрөл	ХЗХ-дын тоо	
		2014 онд	2015.II
1	Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	159	242
	Үүнээс:		
2	Төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	22	116
3	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй	1	1
4	Салбарын зөвшөөрөлтэй	4	4


Хорооны хуралдаанаар тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын зохицуулалтын зарим асуудлыг шийдвэрлэсэн байдлыг харуулбал:

Онууд	Шинээр олгосон	Хүчингүй болгосон	Түдгэл-зүүлсэн	Сэргээсэн	ТЗ-ийн хугацаа сунгасан	ХЗХ-дын тоо (оны эцэст)
2006 он	51	0	0	-	-	51
2007 он	128	0	0	-	-	179
2008 он	45	15	5	-	-	209
2009 он	15	12	8	1	25	212
2010 он	2	35	15	4	80	179
2011 он	4	21	9	-	47	162
2012 он	3	17	7	4	26	148
2013 он	2	9	5	-	76	141
2014 он	25	7	7	3	28	159
2015-II улиралд	86	3	-	1	10	242
Дүн	361	119	56	13	292	

ХЗХ-дын тооны өөрчлөлтийг сүүлийн 10 жилийн байдлаар харуулбал:



Эдгээр ХЗХ-дын гишүүдийн тооны өөрчлөлтийг харуулбал:



ХОЁР. НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Тайлант улиралд нийт ХЗХ-дын 86.4 хувь буюу 209 ХЗХ-доос 2015 оны 2-р улирлын санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан ирүүлж нэгтгэлд хамруулсан бол 13.6 хувь буюу 33 ХЗХ тайлан мэдээг ямар нэгэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Хороонд ирүүлээгүй байна.

2015 оны 2-р улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлд тайлан мэдээгээ ирүүлээгүй 33 ХЗХ-дын нэгтгэлд хамруулсан үеийн буюу хамгийн сүүлд Хороонд ирүүлсэн санхүүгийн тайланг хугацааны хувьд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

д/д	Тайлангийн хугацаа	ХЗХ-ны тоо	ХЗХ-дын нэрс
1	2014-IV улирлаар	2	Өсөх өндөр ХЗХ, Ойгоны ирээдүйн сэтгэмж ХЗХ
2	2015-I улирлаар	11	Нэр бүхий 11 ХЗХ
3	Үүсгэн байгуулагдах үеийн эхлэлтийн балансаар ¹	20	Нэр бүхий 20 ХЗХ
Нийт		33	

2.1 Гишүүдийн статистик үзүүлэлтүүд

(тоогоор)

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ	НИЙТ 242 ХЗХ-ДЫН ГИШҮҮДИЙН		ҮҮНЭЭС:			
			Улаанбаатар хот дахь 157 ХЗХ-дын		Орон нутаг дахь 85 ХЗХ-дын	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Гишүүдийн						
Нийт гишүүдийн тоо	35,306	100%	18,834	100%	16,472	100%
Үүнээс: эмэгтэй	19,814	56.1%	11,204	59.5%	8,610	52.3%
Үүнээс: гишүүн хуулийн этгээд	55	0.2%	40	0.2%	15	0.1%
Гишүүдийн насжилт	35,306	100%	18,834	100%	16,472	100%
18-35 насны	9,529	27.0%	5,488	29.1%	4,041	24.5%
36-45 насны	11,241	31.8%	5,620	29.8%	5,621	34.1%
46-55 насны	9,000	25.5%	4,630	24.6%	4,370	26.5%
55-аас дээш	5,536	15.7%	3,096	16.4%	2,440	14.8%
Гишүүдийн боловсрол	35,306	100%	18,834	100%	16,472	100%
Дээд	16,497	46.7%	11,354	60.3%	5,143	31.2%
Тусгай дунд	5,378	15.2%	2,834	15.0%	2,544	15.4%
Бүрэн дунд	7,678	21.7%	3,535	18.8%	4,143	25.2%
Дунд	4,413	12.5%	1,020	5.4%	3,393	20.6%
Бага	1,340	3.8%	91	0.5%	1,249	7.6%
Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо	15,830	44.8%	7,472	39.7%	8,358	50.7%

¹ 2014 оны 3-р улиралд тусгай зөвшөөрөл авсан 1 ХЗХ, 2015 оны 1-р улиралд тусгай зөвшөөрөл авсан 6 ХЗХ, 2015 оны 2-р улиралд тусгай зөвшөөрөл авсан 13 ХЗХ.

Санхүүгийн зохицуулах хороо

Хугацаатай хадгаламжтай	12,094	34.3%	5,496	29.2%	6,598	40.1%
Хугацаагүй хадгаламжтай	3,736	10.6%	1,976	10.5%	1,760	10.7%
Зээлдэгч гишүүдийн тоо	15,266	43.2%	6,776	36.0%	8,490	51.5%
Хэвийн зээлтэй	14,023	39.7%	6,174	32.8%	7,849	47.7%
Хугацаа хэтэрсэн зээлтэй	715	2.0%	325	1.7%	390	2.4%
Чанаргүй:	528	1.3%	277	1.5%	251	1.10%
Хэвийн бус зээлтэй	189	0.5%	70	0.4%	119	0.7%
Эргэлзээтэй зээлтэй	185	0.5%	88	0.5%	97	0.6%
Муу зээлтэй	154	0.4%	119	0.6%	35	0.2%

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 242 хоршоодын гишүүдийн тоо 35,306-д хүрсэн байгаа нь өмнөх оны мөн үеэс 7,789 гишүүнээр, 2014 оны жилийн эцсээс 4,608 гишүүнээр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нийт гишүүдийн 16,472 буюу 46.7 хувь нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа 85 ХЗХ-дын гишүүд, 18,834 буюу 53.3 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 157 ХЗХ-дын гишүүд байгаа ба нийт гишүүдийн 15,830 буюу 44.8 хувь нь хадгаламж эзэмшигч гишүүд, 15,266 буюу 43.2 хувь нь зээлдэгч гишүүд байна.

2.2 Санхүүгийн ерөнхий үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны II улирал	2015 оны II улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ-дын тоо	139	242	103	74.1%
2	Гишүүдийн тоо	27,517	35,306	7,789	28.3%
3	Нийт актив	76,841,469.7	85,609,086.6	8,762,916.9	11.4%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.4%</i>	<i>0.4%</i>	<i>0.0%</i>	
4	Нийт зээлийн үлдэгдэл	61,539,116.8	70,773,093.2	9,233,976.4	15.0%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.5%</i>	<i>0.6%</i>	<i>0.1%</i>	
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,815,813.0	2,240,627.3	424,814.3	23.4%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.3%</i>	<i>0.3%</i>	<i>0.0%</i>	
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	52,569,553.1	55,818,143.2	3,248,590.1	6.2%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	<i>0.7%</i>	<i>0.8%</i>	<i>0.0%</i>	
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	10,104,833.0	10,420,677.3	311,144.3	3.1%
	<i>Банкны салбарт эзлэх хувь</i>	*	*		
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	7,071,919.4	8,692,295.7	1,620,376.3	22.9%
9	Банк, ББСБ, Төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	1,300,108.0	5,804,766.7	4,504,658.7	346.5%
10	Нийт орлого	9,164,137.8	10,377,765.2	1,213,627.4	13.2%
11	Нийт зардал	7,280,573.7	9,011,865.9	1,731,292.2	23.8%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	1,883,564.1	1,365,899.3	-517,664.8	-27.5%

Тайлант улиралд ХЗХ-ны салбарын гишүүдийн тоо 28.3 хувиар нийт актив 11.4 хувиар тус тус өссөн байна. Мөн нийт зээлийн банкны салбарт эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 0.1 хувиар дээшилсэн байна. Үүнд хадгаламж болон бусдаас авсан зээлийн эх үүсвэр нэмэгдэж байгаа нь зээлийн үлдэгдэл өмнөх оноос 15.0 хувиар өсч банкны салбарт эзлэх хувийг нэмэгдүүлэх хүчин зүйл болсон байна.

"Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийн хүрээнд бичил бизнесийн зээлд иргэдийг хамруулах зорилгоор Нийслэлийн хороодод хадгаламж, зээлийн хоршоог байгуулах үүсгэл санаачлага өрнөсөнтэй холбогдож 4,555,544.5 мянган төгрөгийн санхүүжилтийг ХЗХ-д олгосон нь банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн эх үүсвэрийг өмнөх оны мөн үеэс 3,5 дахин нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна.

Хадгаламж, зээлийн хороодын 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 242 ХЗХ-д байгаагийн 64.9 хувь буюу 157 ХЗХ нь Улаанбаатар хотод, 35.1 хувь буюу 85 ХЗХ нь орон нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа ба үүнийг орон нутгийн байршлаар үзүүлбэл:



2.3 Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны II улирал	2015 оны II улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	УБ хотод үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	57	157	100	175.4%
2	Гишүүдийн тоо	12,252	18,834	6,582	53.7%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	44.5%	53.3%	8.82%	19.8%
3	Нийт актив	65,894,638.1	73,017,908.9	7,118,570.8	10.8%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	85.8%	85.3%	-0.46%	-0.5%
4	Нийт зээлийн үлдэгдэл	53,086,931.0	60,642,784.9	7,555,853.9	14.2%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	86.3%	85.7%	-0.58%	-0.7%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	1,507,208.7	1,899,818.7	392,610.0	26.0%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	83.0%	84.8%	1.78%	2.2%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	47,223,865.9	49,318,735.3	2,094,869.4	4.4%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	89.8%	88.4%	-1.48%	-1.6%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	7,058,825.4	7,297,682.4	234,157.0	3.3%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	69.9%	70.0%	0.16%	0.2%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	5,755,203.5	7,180,604.6	1,425,401.1	24.8%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	81.4%	82.6%	1.23%	1.5%
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	538,614.9	4,936,544.5	4,397,929.6	816.5%
10	Нийт орлого	7,478,720.9	8,329,392.3	850,671.4	11.4%
11	Нийт зардал	5,956,215.5	7,378,507.2	1,422,291.7	23.9%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	1,522,505.4	950,885.1	-571,620.3	-37.5%

Санхүүгийн зохицуулах хороо

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй 157 ХЗХ-дын нийт актив 73,017,908.9 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 85.3 хувийг, орлого 8,329,392.3 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт орлогын 80.3 хувийг, зардал 7,378,507.2 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 81.9 хувийг тус тус эзэлж байна.

2.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын статистик үзүүлэлтүүд

(мянган төгрөгөөр)

д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2014 оны II улирал	2015 оны II улирал	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо	82	85	3	3.7%
2	Гишүүдийн тоо	15,265	16,472	1,207	7.9%
	<i>ХЗХ-ны гишүүдийн нийт тоонд эзлэх хувь</i>	55.5%	46.7%	-8.82%	-15.9%
3	Нийт актив	10,946,831.6	12,591,177.7	1,644,346.1	15.0%
	<i>ХЗХ-ны нийт активт эзлэх хувь</i>	14.2%	14.7%	0.46%	3.2%
4	Нийт зээлийн үлдэгдэл	8,452,185.8	10,130,308.2	1,678,122.4	19.9%
	<i>ХЗХ-ны нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	13.7%	14.3%	0.58%	4.2%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	308,604.3	340,808.6	32,204.3	10.4%
	<i>ХЗХ-ны нийт чанаргүй зээлийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	17.0%	15.2%	-1.78%	-10.5%
6	Нийт татсан хадгаламжийн үлдэгдэл	5,345,687.2	6,499,407.9	1,153,720.7	21.6%
	<i>ХЗХ-ны нийт хадгаламжийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	10.2%	11.6%	1.48%	14.5%
7	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	3,046,007.6	3,122,994.8	76,987.2	2.5%
	<i>ХЗХ-ны нийт хувь хөрөнгийн үлдэгдэлд эзлэх хувь</i>	30.1%	30.0%	-0.16%	-0.5%
8	Нийт хоршоологчдын өмчийн дүн	1,316,715.9	1,511,691.2	194,975.3	14.8%
	<i>ХЗХ-ны нийт хоршоологчдын өмчийн дүнд эзлэх хувь</i>	18.6%	17.4%	-1.23%	-6.6%
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн дүн	761,493.1	868,222.2	106,729.1	14.0%
10	Нийт орлого	1,685,417.0	2,048,372.9	362,955.9	21.5%
11	Нийт зардал	1,324,358.3	1,633,358.7	309,000.4	23.3%
12	Тухайн үеийн ашиг	361,058.7	415,014.2	53,955.5	14.9%

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 85 ХЗХ-дын нийт актив 12,591,177.7 мянган төгрөг байгаа нь салбарын нийт активын 14.7 хувийг, орлого 2,048,372.9 мянган төгрөг байгаа нь нийт орлогын 19.7 хувийг, зардал 1,633,358.7 мянган төгрөг байгаа нь нийт зардлын 18.1 хувийг тус тус эзэлж байна.

ГУРАВ. НИЙТ ХӨРӨНГИЙН БҮТЭЦ, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

3.1 Хөрөнгийн бүтэц

ХЗХ-дын 2015 оны 2 дугаар улирлын байдлаарх нийт хөрөнгийн бүтцийг 2014 оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

№	ХӨРӨНГӨ	2014.06.30		2015.06.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
	1.ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	74,738,962.2	97.3%	83,307,180.2	97.3%	8,568,218.0	11.5%
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ	11,127,829.3	14.5%	10,919,038.5	12.7%	(208,790.8)	-1.9%
	Бэлэн мөнгө	3,041,236.2	4.0%	2,897,007.7	3.4%	(144,228.5)	-4.7%
	Банкинд байршуулсан харилцах	5,269,305.6	6.9%	3,873,024.0	4.5%	(1,396,281.6)	-26.6%
	Банкинд байршуулсан хадгаламж	2,817,287.5	3.7%	4,149,006.9	4.8%	1,331,719.4	47.3%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	0.0%	-	0.0%	-	0.0%
	Арилжааны үнэт цаас	-	0.0%	-	0.0%	-	0.0%
1.3	ЗЭЭЛ/ЦЭВРЭЭР/	60,606,114.6	78.9%	68,945,630.9	80.5%	8,339,516.3	13.8%
	Нийт зээл	61,539,116.8	80.1%	70,773,093.2	82.7%	9,233,976.4	15.0%
	Хэвийн зээл	57,884,511.3	75.3%	66,177,912.9	77.3%	8,293,401.7	14.3%

Санхүүгийн зохицуулах хороо

	Хугацаа хэтэрсэн зээл	1,838,792.5	2.4%	2,354,553.0	2.8%	515,760.5	28.0%
	Чанаргүй зээл	1,815,813.0	2.4%	2,240,627.3	2.6%	424,814.3	23.4%
	Хэвийн бус зээл	843,820.4	1.1%	547,700.3	0.6%	(296,120.1)	-35.1%
	Эргэлзээтэй зээл	699,824.1	0.9%	978,520.8	1.1%	278,696.7	39.8%
	Муу зээл	272,168.6	0.4%	714,406.2	0.8%	442,237.6	162.5%
	(Зээлийн эрсдэлийн сан)	933,002.2	1.2%	1,827,462.3	2.1%	894,460.1	95.9%
1.4	АВЛАГА	2,251,013.0	2.9%	2,660,874.7	3.1%	409,861.6	18.2%
	Байгууллага, хүмүүсээс авах авлага	139,774.7	0.2%	321,524.1	0.4%	181,749.4	130.0%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	2,111,238.3	2.7%	2,339,350.5	2.7%	228,112.2	10.8%
1.5	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	229,745.0	0.3%	229,255.9	0.3%	(489.1)	0%
	Татварын авлага	3,126.1	0.0%	3,394.2	0.0%	268.1	9%
	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	33,763.2	0.0%	31,569.7	0.0%	(2,193.5)	-6.5%
	Дараа тайлангийн тооцоо	7,847.1	0.0%	18,379.6	0.0%	10,532.4	134.2%
	Дутагдал, шамшигдал	126,210.6	0.2%	114,514.7	0.1%	(11,695.8)	0.0%
	Хангамжийн зүйлс	58,798.0	0.1%	61,397.7	0.1%	2,599.8	4.4%
	Салбар хоорондын авлага	-	0.0%	-	0.0%	-	0.0%
1.6	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	524,260.3	0.7%	552,380.2	0.6%	28,119.9	5.4%
	Өмчлөх бусад хөрөнгө	527,060.3	0.7%	607,355.4	0.7%	80,295.2	15.2%
	(Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга)	2,800.0	0.0%	54,975.3	0.1%	52,175.3	1863%
	2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	2,102,507.5	2.7%	2,301,906.4	2.7%	199,398.9	9.5%
2.1	ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ЦЭВРЭЭР/	2,063,558.7	2.7%	2,280,147.8	2.7%	216,589.1	10.5%
	Үндсэн хөрөнгө	2,573,603.6	3.3%	2,816,958.4	3.3%	243,354.8	9.5%
	(Хуримтлагдсан элэгдэл)	510,044.9	0.7%	536,810.6	0.6%	26,765.7	5.2%
2.2	БИЕТ БУС ХӨРӨНГӨ	8,908.8	0.0%	6,738.6	0.0%	(2,170.2)	-24.4%
	Биет бус хөрөнгө	10,820.2	0.0%	12,780.2	0.0%	1,960.0	18.1%
	(Биет бус хөрөнгийн элэгдэл)	1,911.3	0.0%	6,041.6	0.0%	4,130.2	216%
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	30,040.0	0.0%	15,020.0	0.0%	(15,020.0)	-50.0%
2.3	Хөрөнгө оруулалт ба бусад эргэлтийн бус хөрөнгө	30,040.0	0.0%	15,020.0	0.0%	(15,020.0)	-50.0%
	ХӨРӨНГИЙН ДҮН	76,841,469.7	100%	85,609,086.6	100%	8,767,616.9	11.4%

Активын хэмжээ өмнөх онтой харьцуулахад 11.4 хувиар буюу 8,767,616.9 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд эргэлтийн хөрөнгө тэр дундаа нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувиар буюу 9,233,976.4 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн.

Салбарын хэмжээгээр нийт активын өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулвал:



3.2 Активын төвлөрлийг активын хэмжээ болон байршлаар нь авч үзвэл

Үүнд: **Активын хэмжээгээр:**

(мянган төгрөгөөр)

№	Активын хэмжээ	ХЗХ-	Нийт актив	Гишүүдийн тоо	Байршил
---	----------------	------	------------	---------------	---------

Хадгаламж, зээлийн хоршоодын 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Санхүүгийн зохицуулах хороо

		дын тоо	Дүн	Хувь	Тоо	Хувь	УБ	Орон нутаг
1	10,000,000.0 дээш	1	29,597,633.6	34.6%	3,263	9.2%	1	-
2	1,000,000.0-10,000,000.0	10	33,408,285.0	39.0%	6,351	18.0%	9	1
3	500,000.0-1,000,000.0	7	4,881,221.9	5.7%	4,197	11.9%	2	5
4	100,000.0-500,000.0	71	13,259,110.3	15.5%	12,700	36.0%	42	29
5	50,000.0-100,000.0	38	2,850,481.3	3.3%	3,085	8.7%	23	15
6	10,000.0-50,000.0	49	1,468,609.3	1.7%	3,368	9.5%	20	29
7	10,000.0 хүртэл	66	143,745.3	0.2%	2,342	6.7%	60	6
	Нийт дүн	242	85,609,086.6	100%	35,306	100%	157	85

ХЗХ-дын активын төвлөрлийг ангилахад томоохон буюу 1 тэрбум төгрөгөөс дээш актив хөрөнгөтэй 11 ХЗХ-ны нийт актив 63,005,918.6 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын активын 73.6 хувийг, гишүүдийн тоо 9,614 байгаа нь нийт ХЗХ-дын гишүүдийн 27.2 хувийг тус тус эзэлж байна.

Активын төвлөрлийг байршлаар үзүүлвэл:

(мянган төгрөгөөр)


№	Байршил	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Активын хэмжээ	
				Дүн	Хувь
1	Улаанбаатар хот	157	18,834	73,017,908.9	85.29%
2	Орхон аймаг	12	1,936	2,932,069.8	3.42%
3	Баян-Өлгий аймаг	7	3,035	1,722,247.4	2.01%
4	Хэнтий аймаг	4	1,172	1,122,065.1	1.31%
5	Завхан аймаг	8	1,574	1,007,087.6	1.18%
6	Архангай аймаг	3	655	912,702.5	1.07%
7	Дорнод аймаг	5	1,148	864,198.0	1.01%
8	Төв аймаг	4	720	590,522.7	0.69%
9	Өвөрхангай аймаг	2	671	589,814.1	0.69%
10	Дундговь аймаг	6	1,018	552,571.8	0.65%
11	Увс аймаг	5	860	401,103.2	0.47%
12	Баянхонгор аймаг	4	1,108	382,036.7	0.45%
13	Булган аймаг	3	606	285,860.7	0.33%
14	Сүхбаатар аймаг	2	315	213,818.4	0.25%
15	Дорноговь аймаг	5	240	208,037.3	0.24%
16	Дархан-Уул аймаг	2	303	196,917.9	0.23%
17	Өмнөговь аймаг	5	291	189,050.1	0.22%
18	Ховд аймаг	1	286	144,098.4	0.17%
19	Говьсүмбэр аймаг	1	64	108,693.0	0.13%
20	Хөвсгөл аймаг	3	243	107,140.2	0.13%
21	Сэлэнгэ аймаг	3	227	61,142.9	0.07%
	Дүн	242	35,306	85,609,086.6	100%

Улаанбаатар хотод нийт 157 ХЗХ байгаагаас Сүхбаатар дүүрэгт 33 ХЗХ, Чингэлтэй дүүрэгт 29 ХЗХ, Баянгол дүүрэгт 12 ХЗХ, Сонгинохайрхан дүүрэгт 28 ХЗХ, Хан-Уул дүүрэгт 16 ХЗХ, Баянзүрх дүүрэгт 25 ХЗХ, Налайх дүүрэгт 5 ХЗХ, Багануур дүүрэгт 8 ХЗХ, Багахангай дүүрэгт 1 ХЗХ тус тус тусгай зөвшөөрөлтэйгээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.

Орон нутагт 21 аймгаас Говь-Алтай аймагт хадгаламж, зээлийн хоршоо байхгүй бөгөөд бусад 20 аймагт 85 ХЗХ тусгай зөвшөөрөлтэйгээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна.


3.3 Зээлийн үйл ажиллагааны талаар

Зээлийн чанарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



Цэвэр зээлийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,339,516.3 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар өссөн бол чанаргүй зээлийн үлдэгдэл 424,814.3 мянган төгрөгөөр буюу 23.4 хувиар өссөн байна.

Зээлийн багцыг өмнөх жилүүдтэй харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:



Тайлант улирлын байдлаар ХЗХ-дын нийт зээлийн багц 70,773,093.2 мянган төгрөг байгаа нь активын 82.7 хувьтай, цэвэр зээл 68,945,630.9 мянган төгрөг байгаа нь активын 80.5 хувьтай тус тус тэнцэж байна.

Тусгай зөвшөөрөлтэй ХЗХ-дын тайлант улиралд олгосон төлөгдсөн зээл дараах байдалтай байна. Үүнд:

ҮЗҮҮЛЭЛТ	Нийт 242 ХЗХ	ҮҮНЭЭС:
----------	--------------	---------

		Улаанбаатар хот	Орон нутаг
Зээлийн эхний үлдэгдэл	61,259,328.0	52,354,952.9	8,904,375.1
Олгосон зээл	113,285,056.2	103,429,635.7	9,855,420.5
Төлөгдсөн зээл	103,771,291.0	95,141,803.7	8,629,487.4
Зээлийн эцсийн үлдэгдэл	70,773,093.2	60,642,784.9	10,130,308.2

Нэгтгэлд хамрагдаж байгаа 242 ХЗХ-д 2014 оны жилийн эцэст 61,259,328.0 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант улиралд нийт 113,285,056.2 мянган төгрөгийн зээл олгож, 103,771,291.0 мянган төгрөгийн зээл төлөгдөж, 2015 оны эхний хагас жилд 15,266 гишүүний 70,773,093.2 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй болсон байна.

Тайлант улиралд олгосон зээлийн зориулалт дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Нийт		Улаанбаатар хот		Орон нутаг	
	Дүн	Зээлдэгч гишүүд тоо	Дүн	Зээлдэгч гишүүд тоо	Дүн	Зээлдэгч гишүүд тоо
НИЙТ ОЛГОСОН ЗЭЭЛ	113,285,056.2	11,375	103,429,635.7	4,879	9,855,420.5	6,496
1. Иргэнд олгосон зээл	51,662,975.8	11,314	41,849,173.2	4,864	9,813,802.6	6,450
<i>Бизнесийн зээл</i>	<i>39,771,405.3</i>	<i>5,358</i>	<i>35,476,134.2</i>	<i>2,613</i>	<i>4,295,271.1</i>	<i>2,745</i>
-Үйлдвэрлэл	7,465,401.9	1,399	6,679,561.5	859	785,840.4	540
-Үйлчилгээ	23,739,717.0	1,773	22,569,110.3	1,134	1,170,606.7	639
-Газар тариалан	584,022.4	248	267,183.7	72	316,838.7	176
-Мал аж ахуй	1,376,428.6	951	238,300.0	72	1,138,128.6	879
-Бусад	6,605,835.4	987	5,721,978.8	476	883,856.6	511
<i>Хэрэглээний зээл</i>	<i>11,891,570.5</i>	<i>5,956</i>	<i>6,373,039.0</i>	<i>2,251</i>	<i>5,518,531.6</i>	<i>3,705</i>
-Өрхийн	7,488,148.9	4,633	3,540,667.5	1,721	3,947,481.3	2,912
-Сургалтын төлбөр	392,841.0	235	188,552.5	86	204,288.5	149
-Бусад	4,010,580.7	1,088	2,643,818.9	444	1,366,761.8	644
2.Хуулийн этгээдэд олгосон зээл	61,622,080.4	61	61,580,462.5	15	41,617.9	46
-Үйлдвэрлэл	115,309.5	1	115,309.5	1	0.0	-
-Үйлчилгээ	61,464,153.0	12	61,464,153.0	12	-	-
-Газар тариалан	5,000.0	1	-	-	5,000.0	1
-Мал аж ахуй	36,617.9	45	-	-	36,617.9	45
-Бусад	1,000.0	2	1,000.0	2	-	-

Эхний хагас жилд нийт олгосон зээлийн 45.6 хувь буюу 51,662,975.8 мянган төгрөг нь 11,314 иргэнд олгосон зээл байгаа бол 54.4 хувь буюу 61,622,080.4 мянган төгрөг нь 61 хуулийн этгээдэд олгосон зээл байна.

ДӨРӨВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ, ХАДГАЛАМЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

4.1 Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн талаар

Нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)


№	ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2014.06.30		2015.06.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
	1. ӨР ТӨЛБӨР	59,088,061.8	76.9%	66,117,634.5	77.2%	7,029,572.7	11.9%
1.1	ХАДГАЛАМЖ	52,569,553.1	68.4%	55,818,143.2	65.2%	3,248,590.1	6.2%
	Хугацаагүй	1,732,977.4	2.3%	1,329,969.6	1.6%	(403,007.7)	-23.3%
	Хугацаатай	50,836,575.7	66.2%	54,488,173.6	63.7%	3,651,597.9	7.2%
1.2	БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ	893,768.4	1.2%	2,095,313.0	2.4%	1,201,544.6	134.4%
	Банкнаас авсан зээл	801,004.5	1.0%	633,562.2	0.7%	(167,442.3)	-20.9%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	44,448.7	0.1%	319,769.5	0.4%	275,320.8	619.4%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	48,315.2	0.1%	1,040,981.3	1.2%	992,666.1	2055%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн тусалцаа	-	0.0%	101,000.0	0.1%	101,000.0	0.0%
1.3	БУСАД БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,218,400.7	6.8%	4,494,724.6	5.3%	(723,676.1)	-13.9%
	Цалингийн өглөг	24,589.7	0.0%	47,692.9	0.1%	23,103.1	94.0%

Санхүүгийн зохицуулах хороо

	Татвар, НДШ, ЭМДШ-ийн өглөг	167,615.8	0.2%	184,321.8	0.2%	16,706.0	10.0%
	Ногдол ашгийн өглөг	1,593,028.5	2.1%	401,392.6	0.5%	(1,191,635.9)	-74.8%
	Санхүүгийн түрээсийн өглөг	1,240.5	0.0%	2,015.0	0.0%	774.5	62.4%
	Санхүүгийн түрээсийн хэрэгжээгүй орлого	825.5	0.0%	-	0.0%	(825.5)	0.0%
	Урьдчилж орсон орлого	67,768.6	0.1%	35,919.2	0.0%	(31,849.4)	-47.0%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3,289,482.9	4.3%	3,738,931.1	4.4%	449,448.2	13.7%
	Салбар хоорондын тооцоогоорх өглөг	6,865.9	0.0%	29,992.7	0.0%	23,126.8	336.8%
	Бусад богино хугацаат өглөг	66,983.3	0.1%	54,459.4	0.1%	(12,524.0)	-18.7%
1.4	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	406,339.6	0.5%	3,709,453.7	4.3%	3,303,114.1	812.9%
	Банкнаас авсан зээл	341,107.8	0.4%	284,006.0	0.3%	(57,101.8)	-16.7%
	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	44,625.0	0.1%	172,437.5	0.2%	127,812.5	286.4%
	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	19,122.7	0.0%	3,054,944.5	3.6%	3,035,821.8	15875%
	Тогтворжилтын сангийн санхүүгийн туслалцаа	-	0.0%	196,000.0	0.2%	196,000.0	0.0%
	Хойшлогдсон татварын өр төлбөр	1,484.1	0.0%	2,065.7	0.0%	581.5	39.2%
	2. ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	17,753,407.9	23.1%	19,491,452.1	22.8%	1,738,044.1	9.8%
2.1	ГИШҮҮДИЙН ОРУУЛСАН ХУВЬ ХӨРӨНГӨ	10,104,833.0	13.2%	10,420,677.3	12.2%	315,844.3	3.1%
	Гишүүний оруулсан хувь хөрөнгө	10,068,245.9	13.1%	10,336,434.7	12.1%	268,188.8	2.7%
	Идэвхгүй гишүүний оруулсан хувь хөрөнгө	36,587.1	0.0%	84,242.6	0.1%	47,655.5	130.3%
2.2	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	576,655.6	0.8%	378,479.1	0.4%	(198,176.5)	-34.4%
	Дахин үнэлгээний нэмэгдэл	576,655.6	0.8%	378,479.1	0.4%	(198,176.5)	-34.4%
2.3	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧ	7,071,919.4	9.2%	8,692,295.7	10.2%	1,620,376.4	22.9%
	Нөөцийн сан	2,315,141.9	3.0%	2,673,816.5	3.1%	358,674.6	15.5%
	Хандив, тусламж	19,042.3	0.0%	22,554.0	0.0%	3,511.7	18.4%
	Хадгаламж, хамгаалалтын сан	277,946.7	0.4%	562,678.9	0.7%	284,732.2	102%
	Нийгмийн хөгжлийн сан	528,042.9	0.7%	585,959.6	0.7%	57,916.7	11.0%
	Тогтворжилтын сан	267,206.3	0.3%	568,864.5	0.7%	301,658.2	0.0%
	Бусад сангууд	599,598.7	0.8%	764,548.1	0.9%	164,949.4	27.5%
	Хуримтлагдсан орлого /алдагдал/	3,064,940.6	4.0%	3,513,874.1	4.1%	448,933.6	14.6%
	Тайлангийн үеийн цэвэр орлого	1,883,564.1	2.5%	1,365,899.3	1.6%	(517,664.8)	-27.5%
	Өмнөх үеийн цэвэр орлого	1,181,376.5	1.5%	2,147,974.8	2.5%	966,598.3	81.8%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,841,469.7	100%	85,609,086.6	100%	8,767,616.9	11.4%

ХЗХ-дын өр төлбөр, өөрийн хөрөнгийн хэмжээ буюу эх үүсвэр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,767,616.9 мянган төгрөгөөр өссөн. Энэ өсөлтөд хадгаламжийн хэмжээ 3,248,590.1 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар, банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 4,504,658.7 мянган төгрөгөөр буюу 346.5 хувиар, хоршоологчдын өмч 1,620,376.4 мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх жилүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



4.2 Хадгаламжийн үйл ажиллагааны талаар

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 55,818,143.2 мянган төгрөг буюу нийт эх үүсвэрийн 65.2 хувийг эзэлж байгаа бөгөөд үүний 54,488,173.6 мянган төгрөг буюу 97.6 хувь нь

Санхүүгийн зохицуулах хороо

12,094 гишүүний хугацаатай хадгаламж байгаа бол 1,329,969.6 мянган төгрөг буюу 2.4 хувь нь 3,736 гишүүний хугацаагүй хадгаламж байна.

Үүнийг интервалаар бүлэглэн харуулбал:

(мянган төгрөгөөр)

№	Хадгаламжийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хадгаламжийн дүн	Нийт хадгаламжид эзлэх хувь	Хадгаламж эзэмшигч гишүүдийн тоо
1	10,000,000.0 дээш	1	22,273,473.9	39.9%	1,276
2	1,000,000.0-10,000,000.0	7	22,241,841.0	39.8%	2,985
3	500,000.0-1,000,000.0	4	2,806,010.0	5.0%	605
4	100,000.0-500,000.0	23	5,585,059.9	10.0%	4,067
5	50,000.0-100,000.0	21	1,475,880.4	2.6%	2,475
6	10,000.0-50,000.0	54	1,245,039.2	2.2%	2,864
7	5,000.0-10,000.0	11	88,627.1	0.2%	305
8	5,000.0 хүртэл	57	102,211.6	0.2%	1,253
9	Хадгаламжгүй	64	-	0.0%	-
Нийт хадгаламжийн дүн		242	55,818,143.2	100%	15,830

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдлийг ангилахад 500,000.0 мянган төгрөгөөс дээш хадгаламжийн үлдэгдэлтэй 12 ХЗХ-ны хадгаламжийн үлдэгдэл 47,321,325.0 мянган төгрөг байгаа нь нийт ХЗХ-дын хадгаламжийн үлдэгдлийн 84.8 хувийг эзэлж байгаа бол хадгаламж татан төвлөрүүлээгүй 64 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 26.4 хувийг эзэлж байна.

Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулвал:

(тэрбум төгрөгөөр)



4.3 Бусдаас авсан зээл

(мянган төгрөгөөр)

№	Бусдаас авсан зээл	УБ хот		Орон нутаг	
		Дүн	ХЗХ-дын тоо	Дүн	ХЗХ-дын тоо
1	Банкнаас авсан зээл	245,000.0	4	672,568.2	20
2	Санхүүгийн байгууллагаас авсан зээл	136,000.0	2	149,465.6	10
3	Төсөл, хөтөлбөрөөс авсан зээл	4,555,544.5	49	44,122.7	2
Нийт дүн		4,936,544.5	55	866,156.5	32

"Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-өөс Улаанбаатар хотын 48 ХЗХ 4,555,544.5 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна.

4.4 Хувь хөрөнгийн талаар

Тайлант улиралд гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ 10,420,677.3 мянган төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 12.2 хувийг эзэлж байна. Үүнийг интервалаар харуулбал:

(мянган төгрөгөөр)

д/д	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Гишүүдийн тоо	Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн	
				Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	2	3,686	3,222,934.2	30.93%
2	500,000.0-1,000,000.0	1	313	617,035.8	5.92%
3	100,000.0-500,000.0	17	10,000	2,875,979.7	27.60%
4	50,000.0-100,000.0	20	5,660	1,461,151.6	14.02%
5	10,000.0-50,000.0	73	9,665	1,825,091.1	17.51%
6	5,000.0-10,000.0	24	1,658	172,855.1	1.66%
7	5,000.0 хүртэл	105	4,324	245,629.8	2.36%
Хувь нийлүүлсэн хөрөнгийн дүн		242	35,306	10,420,677.3	100%

ХЗХ-дын хувь хөрөнгийн өсөлтийг өмнөх жилүүдтэй харьцуулвал: (тэрбум төгрөгөөр)



4.5 Өөрийн хөрөнгө, хоршоологчдын өмчийн талаар

2015 оны хагас жилийн байдлаар ХЗХ-дын өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 1,738,044.1 мянган төгрөгөөр өсч 19,491,452.1 мянган төгрөгт хүрсэн. Үүнийг интервалаар харуулбал дараах байдалтай байна.

(мянган төгрөгөөр)

д/д	Өөрийн хөрөнгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Өөрийн хөрөнгө	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	3	7,723,024.3	39.62%
2	500,000.0-1,000,000.0	4	2,847,288.6	14.61%
3	100,000.0-500,000.0	27	5,245,810.3	26.91%
4	50,000.0-100,000.0	27	1,891,643.3	9.70%
5	10,000.0-50,000.0	64	1,657,285.5	8.50%
6	10,000.0 доош	109	278,215.2	1.43%
7	Өөрийн хөрөнгөгүй	8	-151,815.1	-0.78%
Нийт өөрийн хөрөнгийн дүн		242	19,491,452.1	100%

Хадгаламж, зээлийн хоршоодын 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

Санхүүгийн зохицуулах хороо

Өр төлбөрийн хэмжээ нь активаас хэтэрсэн буюу өөрийн хөрөнгөгүй болсон 8 ХЗХ тайлант улирлын эцэст байна.

ХЗХ-дын хоршоологчдын өмчийн байдлыг интервалаар харуулбал. Үүнд:

(мянган төгрөгөөр)

д/д	Хоршоологчдын өмчийн дүн /интервалаар/	ХЗХ-дын тоо	Хоршоологчдын өмчийн дүн	
			Дүн	Хувь
1	1,000,000.0 дээш	1	3,120,728.2	35.90%
2	500,000.0-1,000,000.0	2	1,338,282.0	15.40%
3	100,000.0-500,000.0	12	2,508,358.9	28.86%
4	50,000.0-100,000.0	11	795,492.2	9.15%
5	10,000.0-50,000.0	45	1,072,626.4	12.34%
6	5,000.0-10,000.0	21	163,525.8	1.88%
7	1,000.0-5,000.0	31	94,606.6	1.09%
8	1,000.0 хүртэл	48	7,067.7	0.08%
9	Хоршоологчдын өмчгүй /алдагдалтай/	71	-408,392.0	-4.70%
Нийт дүн		242	8,692,295.7	100%

Алдагдалтай ажилласны улмаас хоршоологчдын өмчгүй болсон 71 ХЗХ үйл ажиллагаа эрхэлж байна.

ТАВ. ОРЛОГО, ЗАРДАЛ, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

5.1 ХЗХ-дын орлогын үзүүлэлтүүд

Орлогын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2014.06.30		2015.06.30		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
I. ХҮҮГИЙН ОРЛОГО	8,846,795.3	96.5%	9,979,358.1	96.2%	1,132,562.8	12.8%
Зээлийн хүүгийн орлого	8,503,247.7	92.8%	9,614,056.6	92.6%	1,110,808.9	13.1%
Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн орлого	88,539.4	1.0%	118,504.1	1.1%	29,964.6	33.8%
Үнэт цаасны хүүгийн орлого	17.0	0.0%	109.0	0.0%	92.0	541.1%
Банк, санхүүгийн байгууллагаас авсан хүүгийн орлого	285,835.6	3.1%	277,413.2	2.7%	(8,422.4)	-2.9%
(Зээлийн хүүгийн орлогын буцаалт)	30,844.5	0.3%	30,724.9	0.3%	(119.6)	-0.4%
II. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО	150,692.2	1.6%	175,864.7	1.7%	25,172.5	16.7%
Элсэлтийн хураамж	8,080.9	0.1%	23,972.7	0.2%	15,891.8	196.7%
Гишүүний татвар	15,572.4	0.2%	20,810.8	0.2%	5,238.5	33.6%
Үйлчилгээний шимтгэл, хураамж	104,051.9	1.1%	115,386.3	1.1%	11,334.5	10.9%
Түрээсийн орлого	16,520.3	0.2%	7,879.0	0.1%	(8,641.3)	-52.3%
Санхүүгийн бусад ажил, үйлчилгээний орлого	6,466.7	0.1%	7,815.8	0.1%	1,349.1	20.9%
III. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	166,650.4	1.8%	222,542.5	2.1%	55,892.1	33.5%
Үндсэн хөрөнгө борлуулсны олз	828.9	0.0%	83,535.5	0.8%	82,706.7	9978%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	66.7	0.0%	71.1	0.0%	4.4	6.6%
Бусад орлого	165,754.8	1.8%	138,935.8	1.3%	(26,819.0)	-16.2%
НИЙТ ОРЛОГО	9,164,137.8	100%	10,377,765.2	100%	1,213,627.4	13.2%

2015 оны 2-р улиралд ХЗХ-дын нийт орлого 10,377,765.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,213,627.4 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар өссөн байна.

Энэ нь зээлийн хүүгийн орлого 1,132,562.8 мянган төгрөгөөр буюу 12.8 хувиар, үйл ажиллагааны бусад орлого 25,172.5 мянган төгрөгөөр буюу 16.7 хувиар, үйл ажиллагааны бус орлого 55,892.1 мянган төгрөгөөр буюу 33.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй холбоотой байна.

5.2 ХЗХ-дын зардлын үзүүлэлтүүд

Зардлын бүтцийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	6/30/2014		6/30/2015		Өөрчлөлт	
	Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
I. ХҮҮГИЙН ЗАРДАЛ	4,711,307.9	64.7%	5,338,252.8	59.2%	626,944.9	13.3%
Хадгаламжийн хүүгийн зардал	4,642,853.6	63.8%	5,192,472.9	57.6%	549,619.3	11.8%
Банк, санхүүгийн байгууллагад төлсөн хүүгийн зардал	100,385.7	1.4%	167,966.1	1.9%	67,580.4	67.3%
Санхүүгийн түрээсийн хүүгийн зардал	424.2	0.0%	1,071.1	0.0%	646.9	152.5%
Бусад хүүгийн зардал	4.4	0.0%	3,187.8	0.0%	3,183.4	72349%
(Хүүгийн зардлын буцаалт)	32,360.0	0.4%	26,445.0	0.3%	(5,914.9)	-18.3%
II. БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН САНГИЙН ЗАРДАЛ	243,020.1	3.3%	871,941.7	9.7%	628,921.6	258.8%
Зээлийн эрсдэлийн зардал	321,112.0	4.4%	827,389.7	9.2%	506,277.7	157.7%
Өмчлөх бусад хөрөнгийн үнэлгээний хасагдуулга	-	0.0%	53,525.3	0.6%	53,525.3	-
(Болзошгүй эрсдэлийн сангийн нөхөлт)	78,092.0	1.1%	8,973.3	0.1%	(69,118.7)	-88.5%
III. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	2,082,555.8	28.6%	2,602,381.8	28.9%	519,826.0	25.0%
Боловсон хүчний зардал	1,329,213.8	18.3%	1,687,495.8	18.7%	358,282.0	27.0%
Бусад төрлийн зардал	753,342.1	10.3%	914,886.1	10.2%	161,544.0	21.4%
IV. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	24,922.7	0.3%	24,408.8	0.3%	(513.9)	-2.1%
Торгуулийн зардал	392.0	0.0%	1,685.4	0.0%	1,293.4	330.0%
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	959.0	0.0%	11,649.5	0.1%	10,690.5	1115%
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	0.9	0.0%	-	0.0%	(0.9)	-100.0%
Үйл ажиллагааны бус бусад зардал	23,570.8	0.3%	11,073.9	0.1%	(12,496.9)	-53.0%
V. ТАТВАРЫН ЗАРДАЛ	218,767.2	3.0%	174,880.8	1.9%	(43,886.4)	-20.1%
НИЙТ ЗАРДАЛ	7,280,573.7	100%	9,011,865.9	100%	1,731,292.2	23.8%

Тайлант улиралд ХЗХ-дын нийт зардлын хэмжээ 9,011,865.9 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,731,292.2 мянган төгрөгөөр буюу 23.8 хувиар өссөн байна.

Үүнд хүүгийн зардал 626,944.9 мянган төгрөгөөр буюу 13.3 хувиар, болзошгүй эрсдэлийн сангийн зардал 628,921.6 мянган төгрөгөөр буюу 258.8 хувиар, үйл ажиллагааны зардал 519,826.0 мянган төгрөгөөр буюу 25.0 хувиар тус тус өссөн үзүүлэлтүүд болон үйл ажиллагааны бус зардал 513.9 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар, татварын зардал 43,886.4 мянган төгрөгөөр буюу 20.1 хувиар тус тус буурсан үзүүлэлтүүд нөлөөлсөн байна.

5.3 Ашигт ажиллагааг өмнөх жилүүдтэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:



5.4 Ашигтай ажиллаж буй ХЗХ-д

Тайлант улиралд 123 ХЗХ-д 1,589,720.0 мянган төгрөгийн ашигтай, 39 ХЗХ ашиг, алдагдалгүй, 80 ХЗХ 223,820.6 мянган төгрөгийн алдагдалтай тус тус ажиллаж салбарын хэмжээнд нийт 1,365,899.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан ба салбарын активын өгөөж 1.6 хувь байна.

Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын ашгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 517,664.8 мянган төгрөгөөр буюу 27.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Ашигтай ажилласан ХЗХ-дыг интервалаар харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

д/д	Ашгийн хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо	Ашгийн хэмжээ	Нийт ашигт эзлэх хувь	Активын хэмжээ	Активын өгөөж
1	100,000.0 дээш	3	667,867.0	42.0%	40,506,111.1	1.65%
2	50,000.0-100,000.0	3	216,229.1	13.6%	6,924,823.7	3.12%
3	10,000.0-50,000.0	24	488,115.1	30.7%	22,925,382.6	2.13%
4	5,000.0-10,000.0	13	92,043.8	5.8%	2,380,760.1	3.87%
5	1,000.0-5,000.0	46	111,605.7	7.0%	5,224,650.6	2.14%
6	1,000.0 хүртэл	34	13,859.3	0.9%	2,107,944.6	0.66%
7	Ашиг, алдагдалгүй	39	-	0.0%	580,027.3	0.00%
	Нийт дүн	162	1,589,720.0	100%	80,649,700.1	1.97%

Эдгээр 162 ХЗХ-доос Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй 92 ХЗХ тайлант улиралд 1,121,054.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь нийт ашгийн 70.5 хувийг эзэлж байгаа ба активын өгөөж 1.6 хувь байна.

Харин орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 70 ХЗХ тайлант улиралд 468,665.7 мянган төгрөгийн ашигтай ажилласан нь нийт ашгийн 29.5 хувийг эзэлж байгаа ба активын өгөөж 4.0 хувь байна.

5.5 Алдагдалтай ажиллаж буй ХЗХ-д

Нийт 242 ХЗХ-дын 33.1 хувь буюу 80 ХЗХ 223,820.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

д/д	Алдагдлын хэмжээ /интервалаар/	ХЗХ-дын тоо		Алдагдлын хэмжээ	Нийт алдагдалд эзлэх хувь
		УБ	Орон нутаг		
1	10,000.0 дээш	4	1	-123,766.0	55.3%
2	5,000.0-10,000.0 хүртэл	1	1	-11,137.5	5.0%
3	1,000.0-5,000.0 хүртэл	26	8	-72,198.1	32.3%
4	1,000.0 хүртэл	34	5	-16,719.0	7.5%
	Нийт дүн	65	15	-223,820.6	100%

Өнгөрсөн оны 2-р улиралд 14 ХЗХ 63,974.4 мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж байсан бол тайлант улиралд 80 ХЗХ 223,820.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байгаа нь алдагдлын хэмжээ 159,846.2 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Гэхдээ энэхүү дүнд үйл ажиллагаа явуулж эхлээгүй буюу тусгай зөвшөөрөл аваад 1 жилийн хугацаа болоогүй үүсгэн байгуулахтай холбоотой эхлэлтийн зардлууд гарсныг нөхөж чадаагүй 59 ХЗХ-ны 72,110.1 мянган төгрөгийн алдагдал орсон болно.

Алдагдалтай ажиллаж байгаа ХЗХ-дын 65 ХЗХ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг ба тэдгээрийн алдагдлын хэмжээ 170,169.1 мянган төгрөг байгаа нь ХЗХ-дын нийт алдагдлын 76.0 хувийг эзэлж байна.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 15 ХЗХ тайлант улиралд 53,651.5 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан нь ХЗХ-дын нийт алдагдлын 24.0 хувийг эзэлж байна.

**ЗУРГАА. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААР**

Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ-дын 2014 оны санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2014 оны 26 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон дагаж мөрдөх үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

№	ЗОХИСТОЙ ҮЗҮҮЛЭЛТ	ЗХШҮ /ДМУ	БАЙВАЛ ЗОХИХ	ТАЙЛАНГААР
А ХӨРӨНГИЙН ЧАНАР БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ				
1	ХӨРӨНГИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН ХҮРЭЛЦЭЭ (мянган төгрөг)		1,458,319.3	1,882,437.5
2	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас бага	3.2%
3	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	30%-иас бага	0.0%
4	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ХАРЬЦАА	ДМУ	30%-иас бага	0.0%
Б ҮР АШИГТАЙ САНХҮҮГИЙН БҮТЦИЙН ҮЗҮҮЛЭЛТ				
1	НИЙТ ХӨРӨНГӨ /АКТИВ/-Д ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	60% - 85%	80.5%
2	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	5% -иас бага	0.6%
3	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	10%-иас бага	2.7%
4	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	20% - 80%	65.2%
5	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	20%-иас бага	6.4%
6	НЭГ ГИШҮҮНИЙ ОРУУЛЖ БОЛОХ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	10%-иас бага	0.0%
7	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас их	10.2%
8	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМУ	869,229.6	2,673,816.5
9	ХАДГАЛАМЖ ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМУ	434,614.8	562,678.9
10	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ (мянган төгрөг)	ДМУ	434,614.8	568,864.5
В ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХЭМЖЭЭ				
11	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ДМУ	15%-иас бага	3.0%
Г ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР				
12	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	ЗХШҮ	5%-иас их	хангасан
Д ӨГӨӨЖ, ЗАРДЛЫН ХУВЬ ХЭМЖЭЭ (ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ ҮЗҮҮЛЭЛТ)				
13	ХӨРӨНГӨ /АКТИВ/-ИЙН ӨГӨӨЖ			1.8%

ХЗХ-дын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр зохистой харьцааны үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр хангаж ажилласан байна. Харин хөрөнгийн эрсдэлийн сангийн хүрэлцээг 424,118.2 мянган төгрөгөөр илүү байгуулсан байна.

2015 оны 2-р улирлын байдлаар үйл ажиллагаа эрхэлж байгаа 242 ХЗХ-доос зохистой харьцааны шалгуур болон дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан 27 ХЗХ байгаа бөгөөд бусад ХЗХ-д нь зохистой харьцааны аль нэг үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна.

Зохистой харьцааны хангасан байдлыг үзүүлэлт бүрээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Шалгуур үзүүлэлтийг хангасан байдал:

№	ҮЗҮҮЛЭЛТ	ХЗХ-ДЫН ТОО	ХЗХ-ДЫН ТООНД ЭЗЛЭХ ХУВЬ
1	Шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	41	16.9%
2	1 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	58	24.0%
3	2 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	28	11.6%
4	3 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	72	29.8%

Санхүүгийн зохицуулах хороо

5	4 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	41	16.9%
6	5 зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	2	0.8%
	Нийт дүн	242	100%

Нийт 242 ХЗХ-дын 16,9% буюу 41 ХЗХ нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант улиралд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Нийт 242 ХЗХ-дын хувьд	
			Хангасан	Хангаагүй
1	ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас бага	220	22
2	НИЙТ ХӨРӨНГӨД ЭЗЛЭХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	60%-85%	117	125
3	ГИШҮҮДИЙН ХАДГАЛАМЖИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-80%	116	126
4	НЭГ ГИШҮҮНИЙ ХУВЬ ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас бага	230	12
5	ХОРШООЛОГЧДЫН ӨМЧИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас их	114	128
6	ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас их	151	91
	Дүн		948	504

Тайлант улиралд чанаргүй зээлийн зохистой харьцааг 22 ХЗХ, нэг гишүүний оруулж болох хувь хөрөнгийн зохистой харьцааг 12 ХЗХ, хоршоологчдын өмчийн зохистой харьцааг 128 ХЗХ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 91 ХЗХ, гишүүдийн хадгаламжийн зохистой харьцааны доод хэмжээг 122 ХЗХ, дээд хэмжээг 4 ХЗХ, нийт хөрөнгөд эзлэх зээлийн зохистой харьцааны доод хэмжээг 63 ХЗХ, дээд хэмжээг 62 ХЗХ тус тус хангаж ажиллаагүй байна.

Дагаж мөрдөх үзүүлэлтийг хангасан байдал:

№	ҮЗҮҮЛЭЛТ	ХЗХ-дын тоо	ХЗХ-дын тоонд эзлэх хувь
1	Дагаж мөрдөх үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан	102	42.2%
2	1 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	63	26.0%
3	2 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	40	16.5%
4	3 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	19	7.8%
5	4 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	11	4.6%
6	5 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	6	2.5%
7	6 дагаж мөрдөх үзүүлэлтийг хангаж ажиллаагүй	1	0.4%
	Нийт дүн	242	100%

Нийт 242 ХЗХ-дын 42,2% буюу 102 ХЗХ нь зохистой харьцааны дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант улиралд зохистой харьцааны дагаж мөрдөх үзүүлэлтүүдийн биелэлт дараах байдалтай байна. Үүнд:

№	ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ДАГАЖ МӨРДӨХ ҮЗҮҮЛЭЛТ	БАЙВАЛ ЗОХИХ	Нийт 242 ХЗХ-дын хувьд	
			Хангасан	Хангаагүй
1	НЭГ ГИШҮҮНД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас бага	200	42
2	НЭГДМЭЛ СОНИРХОЛТОЙ ЭТГЭЭДЭД ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	30%-аас бага	239	3
3	ӨМЧЛӨХ БУСАД ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	5%-аас бага	239	3
4	ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	10%-аас бага	221	21
5	БУСДААС АВСАН ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	20%-аас бага	194	48

Санхүүгийн зохицуулах хороо

6	НӨӨЦИЙН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	Хоршоологчдын өмчийн 10%-аас их	211	31
7	ХАДГАЛАМЖ, ХАМГААЛАЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ	Хоршоологчдын өмчийн 5%-аас их	190	52
8	ТОГТВОРЖИЛТЫН САНГИЙН БАЙВАЛ ЗОХИХ ДООД ХЭМЖЭЭ		193	49
9	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА	15%-аас бага	211	31
	Дүн		1898	280

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

Тайлант улиралд нийт 86 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд 3 ХЗХ нь орон нутагт бусад 83 ХЗХ нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан 83 ХЗХ-ны 82 ХЗХ нь "Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилготойгоор байгуулагдсан болно.

Харин Улаанбаатар хотын "Олон зул" ХЗХ, "Ю Эс Ди Эм" ХЗХ-дын бүх гишүүдийн хурлаар татан буугдах шийдвэр гаргасан, "Фин стар" ХЗХ тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгаагүй, Хорооноос өгсөн удаа дараагийн үүргийг биелүүлээгүй зэрэг үндэслэлээр хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авагдсан байна.

Санхүүгийн тайлангийн нэгтгэлд ХЗХ-д тайланг хамруулж буй байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл 2012 онд 96.0 хувь, 2013 онд 97.2 хувь, 2014 онд 95.0 хувь, 2015 оны 2-р улиралд 86,4 хувийн ирцтэй байна.

ХЗХ-дын салбарын эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Тайлант улиралд ХЗХ-дын нийт активын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,762,916.9 мянган төгрөгөөр буюу 11.4 хувиар өсөж 85,609,086.6 мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.4 хувьтай тэнцэж байна.

2. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 6,582-оор өсч, нийт актив 7,118,570.8 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар, орон нутгийн ХЗХ-дын хувьд гишүүдийн тоо 1,207-оор өсч, нийт актив 1,644,346.1 мянган төгрөгөөр буюу 15.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3. Нийт зээлийн үлдэгдэл 70,773,093.2 мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.6 хувьтай тэнцэж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн багц 8,339,516.3 мянган төгрөгөөр буюу 13.8 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 424,814.3 мянган төгрөг буюу 23.4 хувиар тус тус өссөн байна.

4. Нийт хадгаламжийн үлдэгдэл 55,818,143.2 мянган төгрөг байгаа нь банкны салбарын 0.8 хувьтай тэнцэж байна. Хадгаламжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 3,248,590.1 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн ба нийт мөнгөн хадгаламжийн 97.6 хувь нь хугацаатай, 2.4 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

5. Хувь хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 311,144.3 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өсч, гишүүдийн тоо 7,789-өөр нэмэгдсэн байна. Нийт хувь хөрөнгө тайлант улиралд 10,420,677.3 мянган төгрөг байгаа ба үүний 99.2 хувь буюу 10,336,434.7 мянган төгрөг нь идэвхтэй гишүүний хувь хөрөнгө бол 0.8 хувь буюу 84,242.6 мянган төгрөг нь идэвхгүй гишүүний хувь хөрөнгө байна.

6. Хоршоологчдын өмчийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,620,376.3 мянган төгрөгөөр буюу 22.9 хувиар өссөн. Хувь хөрөнгө болон хоршоологчдын өмчийн хэмжээ өссөн нь бусдын өмнө

ХЗХ-дын хүлээх үүрэг хариуцлага өндөржиж, өөрийн хөрөнгийн чадавхи дээшилсэн эерэг үзүүлэлт гэж дүгнэж байна.

7. ХЗХ-дын санхүүгийн үйл ажиллагаа сайжирч нийт орлогын хэмжээ өмнөх оны мөн үеэс 1,213,627.4 мянган төгрөгөөр буюу 13.2 хувиар, нийт зардлын хэмжээ 1,731,292.2 мянган төгрөгөөр буюу 23.8 хувиар тус тус өсч 2015 оны эхний хагас жилийн байдлаар цэвэр орлого 1,365,899.3 мянган төгрөг байна. Тайлант үеийн ашгийг өмнөх оны мөн үеийн байдалтай харьцуулахад 517,664.8 мянган төгрөгөөр буюу 27.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

8. Тайлант улирлын байдлаар Хорооноос журмаар тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангаж ажилласан 27 ХЗХ байгаа ба эдгээр нь нийт ХЗХ-дын 11.2 хувийг эзэлж байна.

9. Харин зохистой харьцааны шалгуур үзүүлэлийг бүрэн хангаж ажилласан 41 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 16.9 хувийг, дагаж мөрдөх үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан 102 ХЗХ байгаа нь нийт ХЗХ-дын 42.2 хувийг тус тус эзэлж байна.

10. Салбарын хэмжээгээр зээлийн сарын дээд хүү 10%, доод хүү 1.2%, хугацаатай хадгаламжийн сарын дээд хүү 4%, сарын доод хүү 0.6% байгаа бол хугацаагүй хадгаламжийн сарын дээд хүү 1.0%, сарын доод хүү 0.4%-тай байна.

Эдгээрээс ХЗХ-дын хөрөнгө, зээл, хадгаламж, орлого, гишүүдийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтүүд өссөн байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулж үр дүнг нэгтгэн дүгнэвэл нийт активын хэмжээ 11.4%-иар, нийт зээлийн хэмжээ 15.0%-иар өсч нийт орлого 13.2%-иар өссөн байна. Энэхүү хөрөнгийн өсөлтөнд хадгаламжийн 6.2%-ийн өсөлт болон бусдаас авсан зээлийн 3,5 дахин нэмэгдсэн эх үүсвэрийн өсөлт голлон нөлөөлсөн байх бөгөөд үйл ажиллагаа өргөжсөнтэй холбогдож гарсан зардал болон эх үүсвэрийн зардлаас шалтгаалж нийт зардал 23.8%-иар өссөн байна.

Мөн салбарын нийт активын өгөөж 1,8%-тай зохистой харьцааны үзүүлэлтүүдийг салбарын хэмжээгээр бүрэн хангаж ажилласан байгаа нь салбарын үйл ажиллагаа тогтвортой байгааг харуулж байгаа хэдий ч 8 ХЗХ өөрийн хөрөнгөгүй, 71 ХЗХ хоршоологчдын өмчгүй болсон байгааг цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна.

Эдийн засгийн тоон үзүүлэлтээс гадна ХЗХ-дын ирүүлвэл зохих тайлан мэдээг бүрэн авч нэгтгэлд хамруулах, FIN-A програмд шалгаж хүлээж авах ажлыг сайжруулах, хууль, тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах зэрэг зайны хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР